



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 10 сарын 10 өдөр

Дугаар Б/98

Чингис хот

Г.Ариунчимэгийг түр орлон
гүйцэтгэгчээр томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3, 43.3.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй, албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангаж байгаа Гантөмөрийн Ариунчимэгийг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн бодлого хариуцсан мэргэжилтний албан тушаалд 2022 оны 10 дугаар сарын 10-аас эхлэн түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2.Г.Ариунчимэгийн цалинг ТЗ-5-1 шатлалаар тогтоож, үндсэн цалинг 642,388 (зургаан зуун дөчин хоёр мянга гурван зуун наян найм) төгрөгөөр тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3.Байгууллагын дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Г.Ариунчимэгт үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР